



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар 9/530

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйл, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн

дарга:

Аймгийн Засаг даргын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга

Татварын хэлтсийн Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга

Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах Улсын хяналтын байцаагч

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын Хүнсний үйлдвэрлэлийн Улсын байцаагч

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох ажлыг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн дагуу удирдлага арга зүйгээр ханган зохион байгуулж, хэрэгжилтийн

2.

гүйцэтгэлийг танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Батсайхан)-д даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/121 дугаартай захирамжыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ

